

Ариухнаараа үлдсэн нь
(Шинко мууртай ярилцаж буй хэсэг)

1. Өгөгдсөн хэсгээс зөвхөн муурын айж эмээсэн дүр байдлыг үлдээгээд бусдыг алгасан бичье.

Ингэсээр оройн долоо болох үес муур юунаас ч юм цочин нүдээ томоор нээн харлаа. Муур сэрэмжлэх мэт чих нь соотойжээ. Гадаа бүрхүүлтэй дамнуурга барьсан ачаа бараа зөөгчдийн хөлийн чимээ сонсдон байна. Өөр мэдэгдэх юм байсангүй. Гэвч хэдэн хормын дараа гал тогооны харанхуй өрөөнд гэнэт гэрэл гарчээ. Зуухны дэргэдэх дэвсгэр банз, таггүй хувинд хийлттэй байсан ус гялалзах, цонхоор оруулж адарт тогтоосон утас савлах зэрэг нэг нэгнийхээ араас тодрон үзэгдлээ. Муур ус гоожуурын хоолой руу харснаа зугуухан босож иржээ. Тэгтэл энэ үес гоожуурын түүгээрх хаалгыг улмаар нээлхий ханыг нь бороонд шалба норсон нэгэн тэнэмэл эр онгойлгох нь харагдлаа. Хуучирч муудсан алчуур боосон тэр хүн гал зуух руу шагайн өчүүхэн ч чимээгүй өрөөн доторхыг болгоомжлон зогсож чагнав. Өрөөнд нэг ч хүнгүй юм гэдгийг ингэж тандан мэдсэнийхээ дараа борооны нойтон дусал унаж цоохортуулсан сүлжмэл даавуун цувтай тэр хүн гал зуух руу явж орлоо. Муур чихээ хулмайлгаад гэдрэг ухрана. Тэнэмэл энэ бүхнийг анхаарсан нь үгүй толгойдоо боосон алчуурыг яаралгүй тайллаа. Түүний үс нь их ургаж хирэндээ баригдаад зарим газраа шархны тууз наасан үзэгдэнэ. Хэдийгээр иймэрхүү ч гэсэн уг хүний ерөнхий төрх боломжийн аятайхан ажээ.